

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН АХЛАХ ШИНЖЭЭЧ
С.ЦОГЗОЛМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д /д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлого, хэрэгжилт, нэгдсэн санхүүгийн тайланд дүн шинжилгээ, үнэлгээ хийх, салбарын нэгдсэн тайланд төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах, Засгийн газрын тайланд нэгтгүүлэх							
1.	Арга хэмжээ 1.1 Эрүүл мэндийн салбарын 2024 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг хянан хүлээн авч, салбарын тайланг бэлтгэн гаргах	Тайлан өгсөн ЭМБ-ын тоо		2024 оны тайланг стандартын дагуу тайлагнаж СЯ-д хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланд 450 байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч, хянан, нэгтгэн тайлагналаа.	2025.01.15- 2025.04.05	100%
2.	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны нэгтгэсэн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах	Тайлан өгсөн ЭМБ-ын тоо		Аудитын дүгнэлт гарсан байна	Нэгдсэн тайланд 450 байгууллагын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдэж, аудитаас бие даан дүгнэлт гаргасан 353 байгууллагаас 289 байгууллага буюу 81.8 хувь нь өөрчлөлтгүй дүгнэлт авч, 97 байгууллага өмнө онуудад алдаа зөрчилгүй ажилласнаар энэ онд түүвэрт хамрагдан, 59 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв, Энэрэл эмнэлэг, Говь-Алтай аймгийн Тонхил сумын ЭМТ сөрөг дүгнэлт авч, Төв аймгийн	2025.04.10- 2025.04.25	100%

					Баянцагаан сумын ЭМТ, Баян-Өнжүүл сумын ЭМТ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс тус тус татгалзсан байна. Эрүүл мэндийн салбарын нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт авсан.		
3.	Арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны аудитлагдсан нэгтгэсэн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яаманд Засгийн газрын нэгтгэл тайланд нэгтгүүлэх	Нэгтгэгдсэн ЭМБ-ын тоо		Засгийн газрын нэгтгэл тайланд нэгтгэгдсэн байна	Эрүүл мэндийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны аудитлагдсан санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан, тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд хянуулан, Засгийн газрын нэгдсэн тайланд хуулийн хугацаанд нэгтгүүлээ.	2025.04.25 2025.05.10	100%
4.	Арга хэмжээ 1.5. Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүн шинжилгээ, үнэлгээг хийх, аудитын дүгнэлтийг удирдлагын түвшинд танилцуулах	Нэгтгэл, танилцуулга		Удирдлагад танилцуулагдсан байна	Эрүүл мэндийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан, тайлбар танилцуулгыг бэлтгэн Санхүү даатгалын хэлтсийн дарга, Санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1а/1652 албан бичгээр Үндэсний аудитын газрын Ерөнхий аудиторт аудит хийлгэх хүсэлт, 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1а/2101 албан бичгээр Сангийн сайдад нэгдсэн тайлан нэгтгүүлэхээр, 06 дугаар сарын 03-ны өдрийн 1а/2932 албан бичгээр УАГ-ын ерөнхий аудиторт аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах төлөвлөгөөг батлуулан тус тус хүргүүлээ.	2025.04.01 2025.06.30	100%
Зорилт 2. “ Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, эрүүл мэндийг дэмжих сан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэл, тайлагналт, хяналт тавих ”							
1.	Арга хэмжээ 2.1. Хөрөнгө оруулалтын дансанд бүртгэлтэй	Шилжүүлсэн ЭМБ-ын тоо	15	7	2022-2024 онуудад улсын комисс хүлээн авсан 13 барилга, их засварын ажлын баримтын бүрдлийг ханган албан бичгээр	2025.01.01- 2025.06.30	100%

	улсын комисс хүлээн авсан барилга байгууламж их засварыг ашиглагч байгууллагад шилжүүлэх				Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 56, 86, 126 дугаар тогтоолоор 12 барилгыг ашиглагч байгууллагад шилжүүллээ.		
2.	Арга хэмжээ 2.2. Эрүүл мэндийн салбарт хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох гэрээнд үндэслэн гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэх, тайлагнах	281.0 тэрбум төгрөг		Төсөл, арга хэмжээний санхүүжилт хийгдсэн байна	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6 барилга, 1 их засвар нийт 7 арга хэмжээний 10 гүйцэтгэлийг хянан 13.9 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүллээ. Барьцаа данснаас 13 арга хэмжээний гүйцэтгэл болон 13 төслийн байршуулсан барьцаа чөлөөлөн 11.0 тэрбум төгрөгийг шилжүүлсэн. Техник хяналтын данснаас гэрээт ажилтны 5 сарын цалинг тооцон олгож, ХХОАТ, НДШ-ийн гүйлгээг хийлээ. Мөн аудитын төлбөрийн актаар тогтоогдсон 2020-2022 оны техник хяналтын үлдэгдэл 160.0 сая төгрөгийг шилжүүллээ.	2025.01.01-2025.06.30	100%
3.	Арга хэмжээ 2.3 Эрүүл мэндийн сайдын багцын Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг холбогдох тушаал, шийдвэр, гэрээнд үндэслэн санхүүжүүлэх, тайлагнах	1,119.8 тэрбум төгрөг		Тусламж үйлчилгээний санхүүжилт хийгдсэн байна	Эрүүл мэндийн сайдын багцын Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт данснаас холбогдох тушаал, шийдвэр, гэрээнд үндэслэн эхний хагас жилийн байдлаар 742,3 тэрбум төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдлийг бүрдүүлэн санхүүжүүллээ. Үүнд ЭМД-аар дамжуулан гүйцэтгэлээр олгох санхүүжилт, төрөөс төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд олгох дэмжлэг санхүүжилт, НҮБ-аар дамжуулан худалдан авах вакцины санхүүжилт зэрэг гүйлгээнүүд багтана.	2025.01.01-2025.06.30	100%
4.	Арга хэмжээ 2.4. Тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл	9.8 тэрбум төгрөг		Төсөл, арга хэмжээний санхүүжилт	Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/89 тушаалаар 17 иргэний гадаад улсад эмчилгээ хийгдсэн төлбөрийн хөнгөлөлтөд	2025.01.01-2025.06.30	100%

	мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах			хийгдсэн байна	908,4 сая төгрөгийг олголоо. Мөн 2-р хуралдаанд хэлэлцүүлэх 28 иргэний гадаадад эмчлүүлсэн баримтыг шалган, хурлын материалыг бэлтгэн өгсөн.		
5.	Арга хэмжээ 2.5. Эрүүл мэндийн сайдын багцын дүнгээр тайлагнадаг төсөв, санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь тайлагнах, мэдээлэх	Байршуулсан мэдээллийн тоо		Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл хугацаандаа байршсан байна	Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны портал сайтад сар бүр оруулах 3 төрлийн мэдээллийг 18 удаа, 1 дүгээр сарын 10-ны дотор оруулах 1 мэдээллийг тус тус хугацаанд нь байршууллаа.	2025.01.01-2025.06.30	100%
6.	Арга хэмжээ 2.5. Эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд үнэлгээ хийж, хагас жил тутамд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, төсвийн сахилга батыг сайжруулах	Зөвлөмжийн тоо		ЭМБ-уудад зөвлөмж, чиглэл хүргэгдсэн байна	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 7/621 албан бичгээр тайлан ирүүлэхэд анхаарах зөвлөмж, 6 дугаар сарын 6-ны өдрийн 7/2985 албан бичгээр жилийн эцсийн санхүүгийн тайланд гарсан алдаа зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар чиглэл тус тус хүргүүлээ.	2025.01.01-2025.06.30	100%
Зорилт 3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.							
1.	Арга хэмжээ 3.1. Хариуцсан асуудлаарх албан бичиг, өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэх, хариу хүргүүлэх	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо	-	Албан бичиг, өргөдөл гомдол хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	Хариуцсан ажлын чиглэлээр 40 албан бичиг хүлээн авч хариуг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Ирсэн гомдол байхгүй.	2025.01.01-2025.06.30	100%
2.	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлаарх бодлогын баримт бичиг, хууль	Бэлтгэж хүргүүлсэн мэдээллийн тоо		Тогтоосон хугацаанд мэдээллийг бэлтгэж	Санхүүгийн тайлан, тоон мэдээлэлтэй холбоотой тооцоо судалгааг хугацаанд нь гарган өгч ажиллалаа.	2025.01.01-2025.06.30	100%

	тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг бэлтгэж тогтоосон хугацаанд нь холбогдох нэгж болон албан тушаалтанд хүргүүлэх.			холбогдох нэгж болон албан тушаалтанд хүргүүлсэн байна.			
--	---	--	--	---	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	“Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төслүүдийн тайлан гаргах	Тайлангийн тоо		Санхүүгийн тайлан гарч Сангийн яаманд нэгтгэгдсэн байна.	Польш улсын тусламжаар хэрэгжсэн “Орон нутгийн анхан шатны эмнэлгүүдийг түргэн тусламжийн автомашинаар хангах”, Австри улсын ЗГ-ын санхүүжилтээр хэрэгжсэн “Хорт хавдрын навигаци болон стеротактик”, “Түлэнхийн төвийг тоног төхөөрөмжөөр хангах”, “ЭХЭМҮТ-ийн тоног төхөөрөмж шинэчлэх” зэрэг төслийн нэгжгүй хэрэгжиж буй төслүүдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган Сангийн яаманд хүргэн нэгтгүүллээ.	2025.01.01-2025.03.20	100%
2.	Тооцооны нягтлан бодогч Б.Даваажавын өвчтэй байх хугацаанд ажлыг давхар хариуцан гүйцэтгэх	Ажлын гүйцэтгэл		Санхүүгийн хэсгийн шалгуур боловсруулсан байна.	Тооцооны нягтлан бодогчийн өвчтэй байх хугацаанд санхүүгийн баримт материалын бүрдлийг хангах, сарын мэдээ, тайлан гаргах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргэх албан бичгүүдийг боловсруулан батлуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.	2025.05.10-2025.06.30	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчид зориулсан цахим сургалтад тухай бүрд хамрагдах	Сургалт		Сургалтад хамрагдсан байна.	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтаас зохион байгуулдаг тасралтгүй боловсрол олгох багц цахим сургалтаас “Дотоод аудитын хувьсал” сургалтыг сонгон хамрагдлаа.	2025.01.01- 2025.06.30	100%
2.	Арга хэмжээ 2. Эрхэлсэн ажлынхаа хүрээнд Сангийн яам, бусад байгууллагаас зохион байгуулах сургалт, семинарт хамрагдах	Сургалт		Сургалтад хамрагдсан байна.	Сангийн яамнаас танхим болон цахимаар зохион байгуулсан санхүүгийн тайлагналын шинэчилсэн Finperform.gov.mn системийн сургалтад 3 удаа оролцлоо.	2025.01.01- 2025.06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл мэндийн сайдын багцын
төсвийн ерөнхий нягтлан бодогч,
ахлах шинжээч
(Албан тушаал)

.....  С.Цогзолмаа

2025.06.06

(Нэр, гарын үсэг)

(Огноо)